ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ, СОЁЛ

XVI ЗУУНЫ МОНГОЛ—ХЯТАДЫН ХУДАЛДАА

Н. Ариунгуа

XVI зууны Монгол-Хятадын харилцаа, хоёр орны хооронд явагдаж байсан худалдааны талаар эрдэмтэн нэлээд судалгаа хийжээ.[1] Чингэхдээ тэд эдийн засгийн харилцааг улс төрийн харилцаатай нягт уялдаа холбоотой судалсан нь хоёр орны түүхэн харилцааны шинж байдлыг тодорхойлоход үлэмж ач холбогдолтой юм. Эрдэмтэн Г. Серройс ‹‹Мин улсын түүх›› хэмээх хятад хэл дээрх сурвалж материалд тулгуурлан судалгаагаа явуулж X—XVII зууны Хятад—Монголын харилцааны тоймыг гарган зарим нэг сонирхолтой дүгнэлт хийжээ.

Ш. Нацагдорж ‹‹Монголын феодализмын үндсэн замнал›› хэмээх номондоо Юан гүрэн мөхсөний дараа Хятадын эсрэг Монголын феодалуудын явуулж байсан дайныг ‹‹XIII зууны үеийн шууд байлдан эзлэх дээрмийн дайнаас эрс ялгавартай бөгөөд Мин Улсын эдийн засгийн хавчилга, хяхалтын эсрэг, түүний илэрхий түрэмгийллийн эсрэг чиглэж байсан нь тодорхой...›› гэж тэр үеийн Монгол—Хятадын харилцааг тодорхойлжээ.

XV зууны Монгол—Хятадын хооронд явагдаж байсан худалдаа нь бүр эрт дээр үеэс уламжлагдан ирсэн хоёр орны харилцааны нэг гол хэлбэр юм.[2] XV зууны Монгол—Хятадын эдийн засгийн харилцааны талаарх баримт материал бусад үеийнхтэй харьцуулбал нэлээд элбэг билээ. Иймээс XV зууны Монгол—Хятадын эдийн засгийн харилцааг судлах нь эрт дээр үеэс нүүдэлчид хөрш зэргэлдээ Хятад оронтой тогтоож байсан харилцааны шинж байдлыг тодорхойлоход үлэмж ач холбогдолтой юм.

Монгол бол нүүдлийн мал аж ахуйн орон бөгөөд үндсэн хүн ам нь эрт цагаас мал аж ахуйг эрхлэн амьдарч байжээ. Гэвч нүүдэлчдийг хэрэгцээ зөвхөн мал аж ахуйн бүтээгдэхүүнээр хязгаарлагддаггүй байсан учир газар тариалан, гар үйлдвэрийн бүтээгдэхүүнээр гачигдмал байдлаасаа гарахын тулд хөрш зэргэлдээ Хятад улстай худалдаа хийхийг эрмэлзэх нь их байсан байна. Түүхэн баримтаас үзэхэд нүүдэлчид байгалийн гамшигийн уршгаар эдийн засаг нь доройтсон юм уу, эсвэл улс төрийн хувьд суларсан үедээ худалдаа хийхийг Хятадын талд тулган хүлээлгэж байжээ.

Ираны түүхч Жувейни ‹‹Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх›› хэмээх номондоо, нүүдэлчдийг суурьшмал оронтой худалдаа хийх сонирхолтойг тун оновчтойгоор хэлэхдээ: ‹‹Монголчууд ямар нэгэн хот

1. Henry Serruys. Sinp-mongol relations during the Mung. Bruxelles. 1967. Ш. Нацагдорж. «Монголын феодализмын үндсэн замнал», УБ., 1978.

2. Вакамацу «Мингийн үеийн Монголын түүх судлал» (шүүмж)-Дорнодахины түүхийн судлал. 39-р боть. № 3, Киото. 1980. ХП. 31. Ш. Нацагдорж. Дээрх зохиол. 95-р тал.

сууринд суудаггүй, хувцас хийх бөс бараа тэдэнд ховор байдаг учраас худалдаа хийх их хүсэлтэй››[3] гэжээ.

XVI зууны үед монголчууд нь тусгай биеэ даасан улсын хувьд Хятад улстай худалдааны харилцаатай байжээ. Энэ харилцаа олон зуун жил үргэлжлэхдээ, хоёр орны улс төрийн харилцаанаас болж үе үе тасалдаж байсан хэдий боловч их бага ямар нэгэн хэмжээгээр явагдсаар байжээ.

XVI зуунд Монголын байлдан дагууллын үрээр байгуулагдсан Юан гүрэн мөхсөний дараа Монгол—Хятадын эдийн засгийн харилцаа нэг хэсэгтээ тасарсан байна. Үүнээс болж монголчууд нь Мин улсаас худалдаа хийхийг шаардаж эс бүтвэл Хятадын эсрэг дайтдаг байжээ. Гэвч энэ үеийн Монголын довтолгоо нь урьдын байлдан дагууллаас огт өөр, эдийн засгийн учир шалтгаантай байсан байна. Өөрөөр хэлбэл Хятад улс монголчуудын шаардлагаар хилийн худалдаа нээвэл монголчууд довтолгооноо зогсоодог байсныг эрдэмтэд цохон тэмдэглэжээ. Энэ нь санамсаргүй хэрэг биш бөгөөд юуны өмнө нүүдэлчдийн эрхэлж буй аж ахуйн шинж байдлаас урган гарсан зүй ёсны зүйл бололтой.

Мин улс монголчуудыг эрх мэдэлдээ буулган оруулахын тулд худалдаа хийх болзол болгон тэднээс алба барихыг шаардаж зөвхөн энэ үндсэн дээр худалдаа хийхийг зөвшөөрч байжээ.

Монголчуудын алба барих нь нэр төдий байсан буюу зөвхөн Хятадтай худалдаа хийх нэг арга байсан юм гэж Серройс сонирхолтой дүгнэлт хийсэн байна. Чингэхдээ дээрх эрдэмтний энэ дүгнэлтийг тодруулах шаардлагатай байна. Учир нь Хятад улс, тухайлбал Мин улс нүүдэлчдийн хүчирхэг довтолгоог эсэргүүцэн зогсоох чадалгүй болмогцоо худалдаа хийе гэсэн тэдний шаардлагыг аргагүй зөвшөөрч түүнийгээ нүүдэлчин Дундад улсад захирагдан алба барих болов гэж албан ёсоор тайлбарлахыг оролддог байсан бололтой. Үнэндээ нүүдэлчид Хятадтай худалдаа хийх болсноо хэзээ ч захирагдах болзол болгож байгаагүй байна. Үүнийг нотлох нэг баримт бол Монголын хаад Хятадтай худалдаа хийх болсныгоо харин түүнээс алба авах болов гэж үзэж байсан нь цөөнгүй байгаа явдал юм. Ийм ч учраас уг худалдаа хэвийн явагддаг байсан боловч Хятадын тал түүнийг олон удаа Монголын эсрэг дайсагнасан ажиллагаандаа ашиглаж байжээ.

Тухайн үеийн Монгол—Хятадын харилцааны талаар нэг санааг нэмж хэлэхэд, хэрэв нүүдэлчид суурьшмал орны бараагаар хэрэгцээгээ хангах зорилгоор худалдаа хийж байсан бол Хятадууд эдийн засгийн сонирхлоосоо илүү улс төрийн талаар ашиг хонжоо олохыг эрмэлзэж байжээ. Суурьшмал орны бараагаар нүүдэлчдийн үе үе гачигдаж гачигдаж байсан байдлыг Мин улс ашиглан тэднийг эдийн засгийн хараат байдалд оруулан, зарим үед нүүдэлчдийн довтолгооноос биеэ хамгаалах нэг арга болгон хэрэглэж байжээ. Энэ бол бүр эрт дээр үеэс Хятад улс нүүдэлчдийн довтолгооны эсрэг хэрэглэж байсан олон арга хэлбэрийн нэг сономол арга мөн юм.

Ийнхүү түүхэн хөгжлийн явцад Хятад улс нүүдэлчдийн довтолгооныг эсэргүүцэх арга тактик, тэдэнтэй харилцах харилцааны хэлбэрүүдийг сонгон боловсруулахдаа хоёр орны худалдааг өөрийн бодлогын чухал зэвсэг болгож байжээ. Харилцан худалдаа хийх нь зөвхөн Монголд ашигтай Хятадад ямар ч ашиггүй байсан гэж үзэж болохгүй. Мэдээжээр нүүдлийн мал аж ахуйт Монголд газар тариалангийн аж ахуйт Хятадтай худалдаа арилжаа хийх нь эдийн засгийн

3. Ata-Malik Juvani. The history of the world-conqueror. Translated from the Persion by John Andrew Boyle. Vol. 1, p. 77.

хувьд тэргүүн зэргийн ач холбогдолтой байв. Тэр үед Хятадад аж үйлдвэр хөгжөөгүй байсан болохоор мал аж ахуйн гаралтай түүхий эд худалдан авах сонирхол Монголынхоос дутуугүй их байсан нь бас ойлгомжтой билээ. Нүүдэлчидтэй худалдаа хийх нь ялангуяа Умард Хятадын хүн амд туйлын чухал байв. Хятадын газар тариалангийн ажилд зүтгэх үхэр, адуу их хэрэгтэй байснаас гадна түүний гар үйлдвэрт малын арьс шир, нэхий үс, ноос, хялгас, эвэр туурай зэрэг мал аж ахуйн бүтээгдэхүүн их хэрэгтэй байв. Малын мах, сүү, цагаан идээ зэрэг бүтээгдэхүүн Хятадад их хэрэгтэй байжээ.

Гэвч Монгол—Хятадын худалдаа нь нүүдэлчдийн эсрэг Мин улсын явуулж байсан төрийн бодлогоос болж туйлын хязгаарлагдмал байжээ. Уг худалдаа нь хилийн худалдааны шинжтэй байсан бөгөөд Хятадын хойд захын хэдэн боомтоор маш ахар хугацаанд хийгддэг байжээ. Монголчууд нь аль болохоор газраар урт удаан хугацаатай өргөн зах нээхийг эрмэлздэг байсан боловч Мин улсын эрх баригчид тэр бүхнийг ихээхэн хавчиж боодог байжээ. Монголчуудын тууварын ирсэн өдий төдий малаас зөвхөн адууг (нүүдэлчдийн эсрэг морин цэрэг байгуулах зорилгоор) худалдан авч, харин боож хавчих зорилгоор хонь, үхрийг нь авахгүй буцаадаг байсан байна. Энэ нь Хятадад их төлөв бог мал худалдаж, өөрийн хэрэгцээт барааг олж авахаар ирсэн Монголын ядуу малчдад тун бэрхшээл чирэгдэл учруулдаг байсан байна. Энэ тухай нэг баримтаас дурьдахад Алтан хааны хуурай хүү Тодоо хилийн худалдааг эрхэлсэн хятад түшмэдэд хэл байсан нь: ‹‹Монголын баян хүн адуугаар торго арилжаалан авч чадна. Харин ядуу хүн үхэр, хонь зэрэг малтай, манай Монголын аравны хоёр—гурван хувь нь баячууд, бусад нь цөм ядуучууд билээ››[4] Мөн монголчуудын хүссэн бараа таваарыг тэр бүр өгдөггүй, тухайлбал—төмөр эдлэлийг худалдахыг хатуу цаазалсан байжээ. Хилийн хотод болдог албан худалдааны үеэр энгийн нүүдэлчин, тариачин нарын амин хувийн худалдааг хийхэд ч дээрхи дүрэм журамыг чанд мөрдөж, зөрчсөн үед хатуу цээрлүүлэн шийтгэдэг байжээ.

Мин улсын засгийн газрын энэ харгис бодлого нь нүүдэлчдийн зүгээс хүчтэй эсэргүүцэл төрүүлж улмаар дайтахад хүргэдэг байсан байна.
1449—1450 онд дөчин дөрвийг нэгтгэсэн Эсэн хаан, 1541—1570 оны хугацаанд Түмдийн Алтан хан нар Мин улстай цэрэглэн байлдаж байсан нь чухамхүү дээрх байдлаас шалтгаалжээ.

Ер нь худалдаа бол маш дээр үеэс Хятадын дарлагч ангиас бусдын газар орныг булаан эзлэх зэвсэг болж байсан бөгөөд энэ талаар түүхч Ин Ши Ю хятадын худалдаа, түрэмгийлэл хоёр салшгүй холбоотой гэж бичсэн байдаг[5] нь ихээхэн үнэний хувьтай бөгөөд XVXVI зууны Монгол—Хятадын харилцаанд Хятадын энэ уламжлалт бодлого туйлын тод илэрлээ олсон гэж үзэх бүрэн үндэстэй байна.

XVI зууны Монгол-Хятадын харилцаа нь нарийн төвөгтэй байсан нь түүхэнд тодорхой билээ. Хятадын Мин улс умард хөрш Монгол Улсыг эдийн засгийн талаар хавчиж, улс төрийн талаар өөр хооронд нь мөргөлдүүлж хэдэн хэсэг болгон бутаргаж улмаар эрх мэдэлдээ оруулан авах бодлогыг тууштай явуулж байжээ. Гэвч Монгол Улс хэдийгээр феодалын бутралд хүч нь суларсан байсан боловч тусгаар

4. ‹‹Ван ли Угун лу›› (‹‹Ван ли хааны байлдааны гавьяаны тэмдэглэл››) 130-р тал.
5. Yung Shih Yu. Trade and Expansion in. Han China. Berkeley and Los Angeles, 1967, pp. 189. 192.

тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлаа сахин хамгаалж Хятадын түрэмгийллийн эсрэг тэмцсээр байна. Энэ нь XVI зууны Монгол—Хятадын харилцааны үндсэн гол шинж болж байжээ.

МОНГОЛО-КИТАЙСКИХ ТОРГОВЛЯ В ХУІ ВЕКЕ

(Резюме)

В статье рассматриваются некоторые особенности монголо-китайске торговли в XVI веке.

Торговля между Монголией и Китаем носила традиционный характер, хотя временами прерывалась из-за чинимых Минским Китаси препятствий и осложнений в политических отношениях между двумя странами. Заинтересованность в торговле с Китаем у кочевнико объяснялась прежде всего, нх нуждой в потроблении продукция земледальческого оседлого, Китая. Если заинтересованность монголов торговле Китаем объяснялась Нх стремлением удовлетворить нужды кочевого быта, то китайцы в торговле с кочев никами усматривали получить прежде всего политическую выгоду даже не учитывая тот факт, что они сами также нуждались в потреблении скота и животноводческой продукции у кочевников.

Именно всякого рода нажимы и дискреминации Минского Китая в торговле с Монголией в рассматриваемый автором период зачас тую являлись причиной вооруженных столкновений между Монголне и Китаем.

В статье указывается на неразрывную связь китайской торговли е экспан-сионистской сущностью политики Китая, что нашло яркое вы ражение в монголо-китайских отношениях ХУІ в.

В заключении автор подчеркивает, что Монголия, несмотря на свою феодальную политическую раздробленность, в это время сум ла дать отпор агрессивной захватнической политике Минского Кита и отстоять свою независимость.